



ПАРЛАМЕНТ ДАХЬ НАМУУДЫН БОДЛОГЫН БАЙР СУУРИЙН ШИНЖИЛГЭЭ - 2026

“Цогц Хөгжлийн Үндэсний Төв” нь “Бүгд
Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (IRI)”-ийн
дэмжлэгтэйгээр энэхүү хураангуйг бэлтгэлээ.

Агуулга

Өмнөх үг	3
1. Намын Институтчилэл ба Бодлогын Нам	5
1.1 Институтчиллийн тухай ойлголт	5
1.2 Намуудын бодлогын байр сууриа илэрхийлэх яагаад чухал вэ?	6
1.3 Бодлогын байр сууриа илэрхийлэхгүй байхын эрсдэл	7
1.4 Намын институцийн доройтлын шинж тэмдгүүд	7
1.5 Намын институтчилалын зайлшгүй шаардлага	8
2. Улс Төрийн Намын Тухай Хууль ба Санхүүжилт	10
2.1 Монгол Улсын Улс Төрийн Намын тухай хуулийн зохицуулалт	10
2.2 Санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт	10
3. Монголын Намуудын Үзэл Баримтлал ба бодлогын чиглэл	11
3.1 Эрүүл Мэндийн Салбар	11
3.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдал	11
3.1.2 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж	12
3.1.3 Эрүүл мэндийн даатгалын салбарт хувийн хэвшлийн оролцоо	13
3.2 Боловсролын Салбар	14
3.2.1 Төрийн болон хувийн боловсролын байгууллагын харьцаа	14
3.2.2 Хот, хөдөөгийн боловсролын чанар, хүртээмжийн ялгааг бууруулах	15
3.2.3 Боловсролын салбарын багш, ажилчдын хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмж ...	16
3.3 Жижиг, Дунд Бизнесийн Бодлого	17
3.3.1 ЖДҮ-ийг дэмжих хүрээнд татварын орчин	17
3.3.2 ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмж	19
3.3.3 Гарааны бизнес, инновацыг дэмжих бодлого	20
4. Дүгнэлт	21
Ашигласан ном, эх сурвалж	22

Өмнөх үг

Монгол улс олон намын тогтолцоонд шилжсэнээс хойш нийт 9 удаагийн УИХ-ын сонгуулийг зохион байгуулсан. Эдгээр сонгуулиудын үр дүнд нийт 18 улс төрийн нам, эвсэл парламентад суудал авч байсан бол МАН 8 удаа олонх болж 5 удаад дангаар засагласан бол 2 удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд бусад нам эвсэлтэй хамтарсан засгийн газар байгуулсан ажилласан, АН нэг удаа олонх болж дангаар засагласан байна. Харин бусад намууд хамгийн ихдээ 1-6 суудал авч байжээ. Монгол улсад 2026 оны байдлаар нийт 37 бүртгэлтэй улс төрийн нам байна.

Энэ хугацаанд улс оронд ардчилсан үнэт зүйл бүрэлдэн төлөвшиж байгаа хэдий ч улс төрийн намын үйл ажиллагаа ил тод байдал, институтчиллийн асуудлыг сайжруулах шаардлага байсаар байгаа нь өнөөгийн монгол улсад тохиолдоод буй нийгэм, эдийн засгийн хүндрэлүүд, иргэдийн улс төрд итгэх итгэл буурсан, сонгуулийн ирц буурсан зэрэг олон үзүүлэлтүүдээс харж болно.

2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж заасан.

Уг өөрчлөлт нь парламентын төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, олон намын тогтолцоог дэмжих чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Улс төрийн намыг бэхжүүлэх зорилгоор улс төрийн намын тухай хуулийг 2023 онд шинэчлэн найруулсан бөгөөд уг хуульд улс төрийн намын үйл ажиллагаа, санхүү, орлого зарлагын ил тод байдал, төрийн санхүүжилт, хариуцлага тооцох механизм зэргийг тодорхой тусгаж өгсөн. Хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан улс төрийн намууд бүтэц зохион байгуулалт, намын дүрмээ хуульд нийцүүлэн ажиллах ёстой болсон.

Улс төрийн намын шинэчилсэн найруулгад орсон нэг чухал заалт нь төрийн санхүүжилтийн зохицуулалт бөгөөд уг хуулиар:

26.3.1.төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;

26.3.2.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;

26.3.3.төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх гэж заасан.

Уг хуулийн 26 дугаар зүйлийн 4-т зорилтот санхүүжилт ус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна гэж заасан.

Улс төрийн намын тухай хуулийн намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагааг дэмжих дээрх зохицуулалт нь намууд бодлогын нам байх, шийдвэр гаргахдаа судалгаанд суурилсан хандлагыг бэхжүүлэх, бодлогын судалгааны хүрээлэн, нэгжийнхээ санал, дүгнэлтийг тогтмол авч үзэх, бодлого боловсруулах үйл явцдаа тэдэнтэй идэвхтэй хамтран ажиллах практикийг дэмжихэд чиглэж байна.

Тиймээс “Цогц Хөгжлийн Үндэсний Төв” нь “Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн (IRI)”-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад улс төрийн намуудын бодлого, үзэл баримтлалын тодорхой байдлыг нэмэгдүүлэх, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах институтийн чадавхыг дэмжих зорилго бүхий бичил төслийн хүрээнд энэхүү хураангуйг бэлтгэлээ.

Энэхүү судалгааны тайлан нь Монгол Улсын Их Хуралд суудал бүхий таван улс төрийн намын бодлогын байр сууриа харьцуулан шинжилж, намуудын институтчиллийн төвшин болон бодлогын чадавхыг үнэлэх зорилоо.

Судалгааг явуулах хүрээнд УИХ-д суудалтай бүх таван намын дэргэдэх бодлогын судалгааны хүрээлэнд бодлогын байр сууриа гаргаж өгнө үү гэсэн албан бичиг хүргүүлэв. Монгол ардын нам (МАН), Ардчилсан Нам (АН), Үндэсний Эвсэл (ҮЭ), Иргэний Зориг Ногоон Нам (ИЗНН)-уудын дэргэдэх бодлогын хүрээлэнгүүд албан бичгээр бодлогын байр сууриа илэрхийлсэн.

1. Намын Институтчилэл ба Бодлогын Нам

1.1 Институтчиллийн тухай ойлголт

Улс төрийн намын институтчилэл гэдэг нь намын байгууллагын тогтвортой байдал, нийгмийн суурьшилт, нам доторх уялдаа холбоо, намын нийгэмд буй хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэлнэ. Самуэль Хантингтон 1968 онд хэвлэгдсэн *Political Order in Changing Societies* хэмээх бүтээлдээ институтчиллийг хэмжих дөрвөн үндсэн шалгуурыг дэвшүүлсэн байдаг.¹ Скотт Мэйнваринг үүнийг намын тогтолцоонд тусган дөрвөн хэмжүүрээр үнэлэхийг санал болгосон байна. Эдгээр нь

- Системийн тогтвортой байдал,
- Нам-нийгмийн уялдаа,
- Намын легитим шинж,
- Зохион байгуулалтын төлөвшил.²

Хүснэгт 1. Сайн болон сул институтчилэгдсэн намын тогтолцооны идеал хэв шинжүүд³

Хэмжүүр	Сайн институтчилэгдсэн тогтолцоо	Сул институтчилэгдсэн тогтолцоо
Системийн тогтвортой байдал	Маш тогтвортой: гол намууд хэдэн арван жилийн турш тогтвортой оршин тогтнодог.	Нэлээд хувьсамтгай: зарим нам гэнэт огцом унадаг бол зарим нь гэнэт өндөр амжилт үзүүлнэ.
Нам-нийгмийн уялдаа	Намууд нийгэмдээ бат бөх үндэстэй. Ихэнх иргэд нэг намдаа тогтмол санал өгдөг.	Намууд нийгэмтэй сул холбоотой. Иргэдийн цөөнх нэг намд тогтмол санал өгдөг.
Намын легитим шинж	Намуудыг ардчилалд зайлшгүй шаардлагатай институт гэж үздэг.	Олон нийт улс төрийн нам болон сонгуулийн легитим байдалд эргэлздэг.
Намын зохион байгуулалт	Намууд нөөц ихтэй. Хувь удирдагчид чухал хэдий ч намыг давамгайлдаггүй.	Намууд нөөц багатай; хувь удирдагчдын мэдэлд байдаг.

Монгол улсад улс төрийн намд итгэх иргэдийн итгэл буурч, сонгуулийн ирц буурах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал "Улс Төрийн Боловсролын Академи"-аас хийсэн Азийн Барометрийн 2023 оны "Ардчилал, Засаглал, Хөгжил" судалгааны өгөгдөлд үндэслэн хийсэн дүн шинжилгээгээр Монголд төрийн институцүүдийн дотроос улс төрийн намуудад итгэх итгэл хамгийн бага буюу судалгаанд оролцогчдын 80.0% нь "итгэдэггүй" эсвэл "огт итгэдэггүй" гэж хариулсан байна. Улс төрийн намд итгэх итгэл буурч байгаа нь сүүлийн хэдэн сонгуулийн үр дүн, авлига, эдийн засаг, улс төрийн томоохон гэмт хэргийн нөхцөл байдал зэрэг нөлөөлж байна.

¹ Huntington, S. P. (1968). *Political Order in Changing Societies*. Yale University Press.

² Mainwaring, S. (1999). *Rethinking Party Systems in the Third Wave of Democratization*. Stanford University Press.

³ Mainwaring, S. (1999). *Rethinking Party Systems in the Third Wave of Democratization*. Stanford University Press.

Монгол улсад болсон сонгуулиудад оролцсон улс төрийн намууд иргэдэд хэрээс хэтэрсэн амлалтууд өгөх, сонгууль угтсан спорт, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, бэлэн мөнгө, том бүтээн байгуулалт амлах зэргээр санал худалдан авахтай холбоотой асуудлууд зэрэг нийтлэг өрсөлдөх арга барил ашиглаж, улс төрийн сөрөг соёл бий болгож улмаар намын институтчилал, бодлогын нам байх зэрэг асуудалд бага анхаарсан нь иргэдийн итгэлийг алдах, мөрийн хөтөлбөр, сонгуулийн амлалтууд бүрэн хэрэгжихгүй байх зэрэг засаглалын олон асуудлуудыг араасаа дагуулж байна. Түүнчлэн намуудад уригдагч, бүлэг, фракцаас хамааралтай байх, бүр нэг нам нь нөгөө намаас хамааралтай байх зэрэг нөхцөл байдал бодитой үүсээд байгааг намын гишүүд улс төрчид хэлж мэдэгдэх болсон.

Тиймээс намын институтчилалыг сайжруулах улс төрийн намыг нэг хүн, бүлэг, популист амлалтуудаас ангид бодлого тодорхойлох түүнийгээ хэрэгжүүлэх чадавхтай байдлаар хөгжүүлж сайжруулах нь бүх иргэдэд хамааралтай чухал асуудал юм.

1.2 Намуудын бодлогын байр сууриа илэрхийлэх яагаад чухал вэ?

Улс төрийн намыг "нийтлэг зарчим дээр үндэслэн үндэсний ашиг сонирхлыг хамтын хүчин чармайлтаар хангахаар нэгдсэн хүмүүсийн бүлэг" хэмээн тодорхойлсон цагаас эхлэн намын бодлогын байр суурь нь ардчилсан тогтолцооны заавал байх шаардлагатай элемент гэж үзэж иржээ.⁴ Манай улсын хувьд улс төрийн намууд баримтлал дээрээ нэгдсэн гэдэг хэдий ч улс төрийн үзэл баримтлалаасаа эсрэг үйл ажиллагаа явуулах, гишүүдээ бэлтгэх, сургах механизм тодорхойгүй, дийлэнх намуудад ийм бүтэц байхгүй зэргээс шалтгаалан бодлого үнэт зүйлийн тодорхойгүй байдал үүсэх эрсдэлтэй.

а) Сонгогчдын мэдээлэлтэй сонголт хийх эрхийн баталгаа

Бернард Манин (1997) ардчиллын "нэр дэвшигч төвтэй" (audience democracy) хэлбэрт шилжих нь бодлогын өрсөлдөөнийг хувь хүний имиж болгон орлуулж, иргэдийн мэдээлэлтэй сонгох эрхийг эрс бууруулдаг гэж тодорхойлсон.⁵

б) Засгийн газрын хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх

Пшеворски, Стоукс болон Манин (1999) "retrospective voting" буюу өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэн санал өгөх нь ардчилсан хариуцлагын гол механизм болдог гэж онолчилсон байдаг.⁶

в) Намын дотоод ардчилал болон кадр бэлтгэлийн суурь

Кац ба Мэйр (1995) "cartel party" (картелийн нам) хэмээх ойлголтоор бодлогын ялгаагүй намууд тэтгэлэг, төрийн нөөцөд тулгуурлан хаалттай элит бүтэц болж хувирдаг гэж тайлбарласан.⁷

г) Эрдэм шинжилгээ, иргэний нийгэмтэй харилцан үйлчлэлийн суурь

⁴ Burke, E. (1770). Thoughts on the Cause of the Present Discontents. London: Dodsley.

⁵ Manin, B. (1997). The Principles of Representative Government. Cambridge University Press.

⁶ Przeworski, A., Stokes, S. C., & Manin, B. (Eds.). (1999). Democracy, Accountability, and Representation. Cambridge University Press.

⁷ Katz, R. S., & Mair, P. (1995). Changing Models of Party Organization and Party Democracy. Party Politics, 1(1), 5-28.

Хабермас (1996) жинхэнэ ардчилсан тогтолцоо нь намуудын ил тод бодлогын байр суурийн дагуу нийгмийн "deliberative discourse" (зөвлөлдөх яриа хэлцэл) явагддаг байхыг шаарддаг гэж онолчилсон.⁸

1.3 Бодлогын байр сууриа илэрхийлэхгүй байхын эрсдэл

Улс төрийн намуудын бодлогын байр суурийн дутагдал нь зөвхөн ардчилсан хэлбэрийн асуудал бус, засаглалын чанарт шууд нөлөөлдөг систем дэх эмзэг цэг болдог.

- Популизм давамгайлах: *Mudde & Kaltwasser (2017)* - популизм). Популизм нь бодлогын тодорхой байр суурийн хоосрол үүсэх үед гарч ирдэг хариу урвал.⁹
- Авлигын эрсдэл нэмэгдэх: OECD (2016) 41 улсын мэдээлэлд тулгуурлан намын санхүүжилтийн ил тод бус байдал болон авлигын индекс хоорондоо шууд хамааралтай гэдгийг нотолсон.¹⁰
- Засаглалын тогтворгүй байдал: Mainwaring & Torcal (2006) намын тогтолцооны институтчилал сул байгаа нь засаглалын тогтворгүй байдлын гол шалтгаан болдог гэдгийг 18 орны судалгаагаар нотолсон.¹¹
- Иргэдийн улс төрийн үл тоомсорлол: Norris (2011) "policy convergence" нь иргэдийн улс төрийн "disengagement"-ийн гол шалтгаан гэж тодорхойлсон.¹²
- Шинэ гишүүдийн оролцооны замыг хаах: Katz & Mair (2009) картелийн нам шинэ нэр дэвшигчдийн "barrier to entry" механизм болдог гэдгийг онолчилсон.¹³

1.4 Намын институцийн доройтлын шинж тэмдгүүд

Хантингтон (1968)¹⁴ байгууллагын доройтлыг "institutionalization in reverse" гэж нэрлэж, Мейнваринг ба Скалли (1995)¹⁵ Латин Америкийн намуудыг судлан дараах шинж тэмдгүүдийг тодорхойлсон байдаг.

- Намын удирдлагын хувийн хандлага. Вебер (1946): charismatic authority нь rational-legal authority-ийг орлох үед доройтол эхэлнэ.¹⁶
- Идеологийн хоосон байдал. Кирхаймер (1966): "catch-all party" хэмээх хэв шинж.¹⁷

⁸ Habermas, J. (1996). *Between Facts and Norms*. MIT Press.

⁹ Mudde, C., & Kaltwasser, C. R. (2017). *Populism: A Very Short Introduction*. Oxford University Press.

¹⁰ OECD. (2016). *Financing Democracy: Funding of Political Parties and Election Campaigns*. OECD Publishing.

¹¹ Mainwaring, S., & Torcal, M. (2006). Party System Institutionalization and Party System Theory. In *Handbook of Party Politics*. SAGE Publications.

¹² Norris, P. (2011). *Democratic Deficit: Critical Citizens Revisited*. Cambridge University Press.

¹³ Katz, R. S., & Mair, P. (2009). The Cartel Party Thesis: A Restatement. *Perspectives on Politics*, 7(4), 753–766.

¹⁴ Huntington, S. P. (1968). *Political Order in Changing Societies*. Yale University Press.

¹⁵ Mainwaring, S., & Scully, T. R. (Eds.). (1995). *Building Democratic Institutions*. Stanford University Press.

¹⁶ Weber, M. (1946). *From Max Weber: Essays in Sociology*. Oxford University Press.

¹⁷ Kirchheimer, O. (1966). The Transformation of the Western European Party Systems. In *Political Parties and Political Development*. Princeton University Press.

- Санхүүгийн хаалттай байдал. Transparency International (2020): 143 улсын мэдээлэлд тулгуурласан нотолгоо.¹⁸
- Сонгогчдын итгэл сулрах. Далтон (2004): "partisan dealignment" нь 21 оронд харьцуулан судалсан.¹⁹
- Дотоод ардчиллын дутагдал. Михелс (1911): "iron law of oligarchy" онол.²⁰

1.5 Намын институтчилалын зайлшгүй шаардлага

Ардчилсан улс орнуудад улс төрийн намууд нь иргэдийн улс төрийн оролцоог зохион байгуулах, нийгмийн олон талт ашиг сонирхлыг нэгтгэн засаглалын бодлого болгон хөрвүүлдэг. Залуучууд, шинэ гишүүд нь мөнгө, танил талаар бус бодлого, оролцоо, шударга өрсөлдөөнөөр шат шатандаа өсөж гарч ирдэг тогтолцоо бий болсноор нам дотроо ардчилалтай болдог.

Монгол Улсад улс төрийн намын институцчиллыг бэхжүүлэх шаардлага нь зөвхөн улс төрийн намуудын дотоод зохион байгуулалтын асуудал биш бөгөөд парламентын ардчиллын тогтвортой байдал, төрийн бодлогын залгамж чанар, улс төрийн хариуцлага, иргэдийн улс төрийн оролцоо, төлөөллийн чанартай шууд холбоотой институцийн асуудал юм. Ардчилсан тогтолцоонд улс төрийн нам нь иргэдийн олон янзын ашиг сонирхлыг нэгтгэн илэрхийлэх, тэдгээрийг бодлого болгон боловсруулах, сонгуулийн замаар төрийн эрх мэдэлд хүргэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх болон сонгогчдын өмнө улс төрийн хариуцлага хүлээх үндсэн институцийн үүрэгтэй. Иймээс улс төрийн намын чанар, төлөвшил нь парламентын ардчиллын чанарын нэг чухал тодорхойлогч болдог.

Монгол Улсад олон намын тогтолцоо 1990 оноос хойш институцийн хувьд бүрэлдэн тогтсон хэдий ч намын институцчиллыг зөвхөн олон нам оршин тогтнож байгаа эсэхээр хэмжих боломжгүй. Намын институцчилал гэдэг нь тухайн нам сонгуулийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой оршин тогтнох, хувь улс төрчөөс харьцангуй бие даасан байх, тодорхой үзэл баримтлал, бодлогын чиг баримжаатай байх, нийгмийн тодорхой бүлгүүдийн ашиг сонирхлыг төлөөлөх, дотоод ардчилал болон хариуцлагын механизмтай байх зэрэг олон хэмжээст ойлголт юм. Энэ утгаараа Монголын улс төрийн намуудын асуудлыг “нам байгаа эсэх” гэхээс илүү “нам хэр зэрэг институцчилэгдсэн бэ?” гэсэн асуултаар авч үзэх шаардлагатай.

Намын институцчиллын зайлшгүй шаардлагын нэг гол шалтгаан нь улс төрийн үйл явцыг хувь хүн төвтэй байдлаас бодлого, институц төвтэй болгох хэрэгцээ юм. Институцчилал сул үед улс төрийн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрөөс илүү намын лидер, тодорхой улс төрч, фракц болон түүнтэй холбоотой улс төр, эдийн засгийн ашиг сонирхол давамгайлах эрсдэлтэй. Ийм нөхцөлд нам нь нийгмийн ашиг сонирхлыг нэгтгэж, бодлого боловсруулах институц гэхээсээ илүү сонгуулийн үед улс төрийн дэмжлэг төвлөрүүлэх хэрэгсэл болж хувирах магадлалтай. Харин институцчилэгдсэн намын хувьд улс төрийн лидер солигдсон ч намын үндсэн үзэл баримтлал, байгууллагын бүтэц, бодлого боловсруулах чадавх, гишүүдийн оролцоо, дотоод шийдвэр гаргах механизм хэвээр хадгалагдах боломжтой.

¹⁸ Transparency International. (2020). Political Finance Regulations Around the World. TI Report.

¹⁹ Dalton, R. J. (2004). Democratic Challenges, Democratic Choices. Oxford University Press.

²⁰ Michels, R. (1911/1962). Political Parties. Free Press.

Энэ нь төрийн бодлогын тогтвортой байдалтай мөн шууд холбоотой. Ардчилсан нийгэмд Засгийн газар болон улс төрийн эрх баригчид сонгуулийн үр дүнд өөрчлөгдөх нь хэвийн боловч төрийн урт хугацааны бодлого заавал сонгуулийн мөчлөг бүрд үндсээрээ өөрчлөгдөх шаардлагагүй. Институцчилэгдсэн намуудын хувьд бодлого нь хувь хүний улс төрийн байр сууринаас илүү намын үзэл баримтлал, судалгаа, экспертүүдийн боловсруулсан хөтөлбөрт тулгуурлах боломжтой. Үүний үр дүнд улс төрийн эрх мэдэл өөрчлөгдсөн ч төрийн бодлогын залгамж чанар хадгалагдах нөхцөл бүрдэнэ. Харин намын институцийн чадавх сул тохиолдолд сонгуулийн дараа улс төрийн шинэ баг бүрдэхтэй зэрэгцэн бодлого, боловсон хүчин, институцийн тэргүүлэх чиглэлүүд огцом өөрчлөгдөх эрсдэлтэй.

Нөгөө талаас, намын институцчилал нь сонгуулийн өрсөлдөөнийг чанаржуулах чухал нөхцөл юм. Улс төрийн намууд нийгмийн тодорхой асуудлыг судалж, түүний үндсэн дээр бодлого боловсруулж, сонгогчдод ялгаатай хувилбар санал болгож чаддаг болсон үед сонгууль зөвхөн хувь хүмүүсийн нэр хүнд, сурталчилгаа, богино хугацааны амлалтад тулгуурласан өрсөлдөөн биш, бодлогын сонголтын механизм болж хувирна. Өөрөөр хэлбэл, институцчилэгдсэн нам нь иргэдийн улс төрийн шаардлагыг төрийн бодлого болгон хувиргах “зуучлагч институц”-ийн үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэдэг.

Үүнтэй зэрэгцэн намын дотоод ардчилал онцгой ач холбогдолтой. Улс төрийн нам өөрөө дотооддоо шийдвэр гаргах ардчилсан механизмгүй, удирдлага нь цөөн хүний гарт төвлөрсөн, нэр дэвшигч болон бодлогыг тодорхойлох үйл явц хаалттай байвал тухайн намын институцийн төлөвшил хязгаарлагдмал байна гэж үзэх үндэслэлтэй. Харин гишүүдийн оролцоо, удирдлагын сонгууль, нэр дэвшигч тодруулах журам, бодлогын хэлэлцүүлэг, дотоод хяналт зэрэг нь институцийн хувьд тогтсон, ил тод байх тусам намын шийдвэр хувь хүний хүсэл сонирхлоос хамаарах нь буурна. Ийм учраас намын дотоод ардчилал нь зөвхөн намын гишүүдийн эрхийн асуудал биш, улс орны ардчиллын чанарт нөлөөлөх институцийн хүчин зүйл юм.

Мөн намын институцчилал улс төрийн хариуцлагын тогтолцоог тодорхой болгоход чухал ач холбогдолтой. Хэрэв нам тодорхой үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, бодлогын зорилттой бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх институцийн механизмтай бол сонгогчид тухайн намын үйл ажиллагааг сонгуулийн дараагийн мөчлөгт үнэлэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл, “амлалт–хэрэгжилт–үр дүн–сонгогчийн үнэлгээ” гэсэн улс төрийн хариуцлагын мөчлөг бий болно. Харин улс төрийн үйл ажиллагаа хувь хүний нэр хүнд, түр зуурын амлалт, сонгуулийн тактикт төвлөрөх үед сонгогчид тухайн улс төрийн хүчний бодит гүйцэтгэлд хариуцлага тооцох нь илүү төвөгтэй болдог.

Монголын нөхцөлд намын институцчиллыг бэхжүүлэх шаардлага нь улс төрийн санхүүжилт, ашиг сонирхлын зөрчил, клиентелизм болон улс төр, бизнесийн хамаарлыг бууруулах асуудалтай мөн холбогдоно. Намын санхүүжилт ил тод бус, дотоод хяналт сул, улс төрийн шийдвэр цөөн хүний төвлөрсөн нөлөөнд орсон нөхцөлд нам нь нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөхөөс илүү тодорхой бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах эрсдэлтэй. Харин санхүүгийн ил тод байдал, дотоод аудит, хандивын хяналт, нэр дэвшигч тодруулах тодорхой журам, гишүүдийн оролцоо зэрэг институцийн механизм хөгжсөнөөр улс төрийн шийдвэрт хувийн болон бүлгийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах боломж нэмэгдэнэ.

Тиймээс Монгол Улсын хувьд намын институцчиллын асуудлыг зөвхөн улс төрийн намуудын дотоод шинэчлэлийн хүрээнд авч үзэх нь хангалтгүй. Энэ нь төрийн институцийн чанар, парламентын төлөөллийн үр нөлөө, бодлогын тогтвортой байдал, сонгогчдын улс төрийн итгэлцэл, ардчиллын тогтвортой байдалтай холбогдох өргөн хүрээний асуудал юм. Намууд тогтвортой, бодлого төвтэй, нийгэмд суурилсан, дотооддоо ардчилсан, санхүүгийн хувьд ил тод, хувь лидерээс институцийн хувьд хараат бус болох тусам улс төрийн өрсөлдөөн илүү эрүүл, бодлогын хувьд утга учиртай, хариуцлагатай болох нөхцөл бүрдэнэ.

2. Улс Төрийн Намын Тухай Хууль ба Санхүүжилт

2.1 Монгол Улсын Улс Төрийн Намын тухай хуулийн зохицуулалт

2023 оны 7-р сарын 7-нд "Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга"-ыг батлан мөрдүүлсэн.²¹ Тус хуульд улс төрийн намыг байгуулах, бүртгэх, зохион байгуулах, үйл ажиллагаа явуулах, санхүүжүүлэх, хянах, хариуцлага тооцохтой холбоотой харилцааг цогцоор нь зохицуулахтай холбоотой чухал өөрчлөлтүүд тусгагдсан.

Хуулийн нэг гол шинэчлэл нь намын санхүүжилт, ил тод байдал, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан явдал юм. Төрийн санхүүжилтийг тодорхой шалгуураар олгож, түүний тодорхой хэсгийг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоо, улс төрийн боловсрол, бодлогын судалгаа болон намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд зорилтот байдлаар зарцуулах зохицуулалт бий болгосон. Энэ хууль нь улс төрийн намыг зөвхөн сонгуулийн байгууллага бус, бодлого боловсруулах, иргэдийн оролцоог хангах, дотоод ардчиллыг хөгжүүлэх байнгын улс төрийн институц болгон төлөвшүүлэх эрх зүйн суурийг бүрдүүлж байна. Тиймээс Иргэний нийгмийн байгууллагууд, иргэд улс төрийн намаас бодлого, үзэл баримтлалын ил тод байдлыг хангаж хуулийн хүрээнд сайжрах үйл ажиллагааг хүлээж байна.

2.2 Санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн орчинд 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга чухал өөрчлөлт авчирсан. Уг хууль нь намын санхүүжилтийг зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг хангах хэрэгсэл гэж үзэхээс илүүтэй, улс төрийн намыг тогтвортой, бодлого төвтэй, хариуцлагатай институц болгон төлөвшүүлэхэд чиглэсэн санхүүгийн зохицуулалтын тогтолцоог бий болгосон. Хуулийн зорилтод намын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хяналт, санхүүжилт, хариуцлагын эрх зүйн үндсийг тогтоохыг тусгайлан тодорхойлсон нь санхүүжилтийг намын институцийн төлөвшлийн нэг хэсэг болгон авч үзэж байгааг харуулж байна.

Шинэчилсэн зохицуулалтын гол онцлог нь төрийн санхүүжилтийг улс төрийн намд шууд, ямар ч хязгаарлалтгүй олгох бус, тодорхой шалгуурт үндэслэн олгож, зарцуулалтыг тодорхой зорилготой холбосон явдал юм. Тухайлбал, УИХ-ын сонгуулиар нийт сонгогчдын нэг буюу түүнээс дээш хувийн санал авсан нам төрийн санхүүжилт авах эрхтэй бөгөөд төрийн санхүүжилтийн

²¹ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга. (2023). Төрийн мэдээлэл эмхэтгэл, No30. <https://legalinfo.mn>

хэмжээг тухайн намын авсан саналын тоо болон УИХ-д авсан суудлын тоонд үндэслэн тооцохоор хуульчилсан.

Шинэчилсэн хуулийн хамгийн чухал шинэлэг тал нь зорилтот санхүүжилтийн тогтолцоо юм. Төрөөс намд олгож буй санхүүжилтийн тодорхой хэсгийг тухайн намын удирдлага өөрийн үзэмжээр чөлөөтэй зарцуулах бус, хуульд заасан институцийн зорилгод чиглүүлэхийг шаардсан. Тухайлбал, төрийн санхүүжилтийн 20-иос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, тэднийг сургаж бэлтгэхэд, 15-аас доошгүй хувийг намын гишүүд болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд, мөн зорилтот санхүүжилтын 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулах судалгаа, төсөл, хөтөлбөр болон намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд зарцуулахаар хуульчилсан. Эдгээр зохицуулалтыг бүхэлд нь авч үзвэл төрийн санхүүжилтийн тодорхой хэсгийг намын институцийн чадавхыг хөгжүүлэхэд зориулах санхүүгийн механизм бий болгоод байгаа юм.

3. Монголын Намуудын Үзэл Баримтлал ба бодлогын чиглэл

Энэ хэсэгт бид хариу ирүүлсэн дөрвөн намын байр сууриа ижил форматаар тус тус харуулж, эцэст нь нэгдсэн дүгнэлт гаргав.

3.1 Эрүүл Мэндийн Салбар

3.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдал

Монгол Улсын ЭМДС нь 2016 оны шинэчлэлийн дараа санхүүжилтийн сайжруулсан тогтолцоонд шилжсэн хэдий ч байгууллагын бие даасан байдал болон санхүүжилтийн урт хугацааны тогтвортой байдлын хувьд олон сорилттой тулгарсаар байна. Намууд уг суудал дээр дараах байр суурьтай байна.

МАН - Монгол Ардын Намын байр суурь

Тогтвортой байдлыг хангах гол арга зам нь зардлыг механикаар хязгаарлах бус, өвчлөлийн эрсдэлийг бууруулах, анхан шатны тусламжийг бэхжүүлэх, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх тогтолцооны шинэчлэл гэж үзсэн. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг "сангийн урт хугацааны тогтвортой байдлын хөрөнгө оруулалт" гэж үзнэ. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн загварт шилжиж, давхардсан зардлыг бууруулна.

АН - Ардчилсан Намын байр суурь

ЭМДЕГ-ийн засаглал, бие даасан байдлыг бэхжүүлэх эрх зүйн шинэчлэлийг намын гишүүдээс санаачлан өргөн барьсан. Төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн шимтгэлийн хэмжээг бодит өртөгтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх, со-раумент хэрэгжүүлэх, нэмэлт хувийн даатгалыг дэмжих, ЭМДС-ийн орлогыг нэмэгдүүлж цаг тухайд нь төлөлтийг хангах арга хэмжээг баримтална.

Үндэсний Эвслийн байр суурь

Үндэсний үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хамгаалах бодлогоор ажлын байрыг хадгалж, нэмэгдүүлэх нь ЭМДС-ийн орлогын суурийг өргөжүүлэх гол арга зам гэж үздэг. Өөрөөр хэлбэл ЭМДС-ийн орлогын тал дахь шийдэлд тэргүүлэн анхаарч байна.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Монгол Улсын төсөв дэх эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэх, төрөөс хариуцан төлж буй иргэдийн ЭМДС-ийн шимтгэлийн хэмжээг дундаж хувьд ойртуулах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч болон эмийн компаниудтай хэлэлцээр хийх замаар нийт зардлыг бууруулах чиглэлээр ажиллана.

Нэгдсэн аналитик дүгнэлт

Дөрвөн намын байр суурийг харьцуулахад хандлагын тодорхой ялгаа ажиглагдаж байна. МАН болон АН хоёул тогтолцооны шинэчлэлийг голлосон байр суурьтай боловч МАН "зардлыг бууруулах" АН "орлогыг нэмэгдүүлэх" механизмыг илүү онцолж байна. Үндэсний Эвсэл эдийн засгийн өсөлтийг ЭМДС-ийн тогтвортой байдалтай шууд холбосон нь "supply-side" хандлагыг илэрхийлж байна. ИЗНН санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх зарчмыг баримталж байна.

3.1.2 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж

МАН - Монгол Ардын Намын байр суурь

Тусламж үйлчилгээний зохион байгуулалтыг хүн төвтэй, нэгдмэл, тасралтгүй загварт шилжүүлнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын оношилгоо, урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлж, өрх, сумын эрүүл мэндийн төвийн чадавхыг бэхжүүлнэ. Телемедицин, алсын зайн зөвлөгөөг өргөжүүлж, орон нутаг, алслагдсан бүсийн иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

АН - Ардчилсан Намын байр суурь

ЭМДС-ийн нийт зарлагын 1.6%-ийг урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгд зарцуулж байгааг 5–10%-д хүргэнэ. Иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулна. Өгөгдөлд суурилсан, зорилтот бүлэгт чиглэсэн нийтийн эрүүл мэндийн бодлогыг тэргүүлэх чиглэл болгоно.

Үндэсний Эвслийн байр суурь

Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандартыг сайжруулах чиглэлээр эрхэлсэн шадар сайдын хүрээнд анхаарал хандуулан ажиллаж байна. Эмийн хүртээмжийг сайжруулахын тулд чөлөөт бүсийн бодлоготой уялдуулан ажиллаж байна.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Явуулын эмнэлэг, алсын зайн оношилгоо, нийгмийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээний хүртээмжийг, ялангуяа хөдөө орон нутаг, үйлчилгээ муутай бүс нутагт сайжруулах бодлого боловсруулна. Урьдчилан сэргийлэх боломжтой өвчлөлийн ачааллыг бууруулах, эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрийг дэмжинэ.

Нэгдсэн аналитик дүгнэлт

Дөрвөн нам бүгд анхан шатны тусламжийн чадавхыг нэмэгдүүлэх, телемедицин болон цахим шийдлийг ашиглах байр суурьтай нийтлэг байна. Гол ялгаа нь урьдчилан сэргийлэлтийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлсон байдалд юм. Тухайлбал АН 1.6%-иас 5–10% болгох тоон зорилт тавьсан бол бусад намууд чиглэлийн байр суурийг илэрхийлсэн. Үндэсний Эвсэл засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа тул хэрэгжиж буй бодлогыг дурдсан нь байр суурийн онцлог юм.

3.1.3 Эрүүл мэндийн даатгалын салбарт хувийн хэвшлийн оролцоо

МАН - Монгол Ардын Намын байр суурь

Төр, хувийн хэвшлийг эрүүл мэндийн салбарт өрсөлдөгч бус, иргэдэд чанартай үйлчилгээ хүргэх хариуцлагатай түнш гэж үздэг. Хувийн хэвшлийн оролцоо нь чанар, аюулгүй байдал, тэгш хүртээмж, санхүүгийн хамгааллын нэгдсэн стандартад захирагдах ёстой. Гэрээний ил тод байдал, гүйцэтгэлийн шалгуур, чанарын аудит, иргэний эрх ашгийг хамгаалах механизмаар баталгаажуулна.

АН - Ардчилсан Намын байр суурь

Өмчийн хэлбэр үл хамаарч эмнэлгүүдийг гүйцэтгэлд нь үндэслэн бие даалгаж, чанар, үр дүнг дээшлүүлнэ. Төрийн эмнэлгийн зарим үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгээр гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. ЭМДС-ийн санхүүжилт оны эцсээр дуусаж, хувийн эмнэлгийн өглөг хуримтлагдах асуудлыг шийдвэрлэхийг анхаарна.

Үндэсний Эвслийн байр суурь

Чөлөөт өрсөлдөөнийг дэмжих нь зүйтэй гэж үзэж байна. Тиймээс төрийн ачааллыг бууруулах зорилгоор хувийн хэвшлийн даатгалын системийг дэмжих нь зүйтэй гэж үзэж байна.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний иж бүрэн, тогтвортой хүрэхийн тулд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, олон улсын байгууллага, ТББ-уудтай хамтын ажиллагааг идэвхжүүлнэ. Бүх иргэд санхүүгийн ямар ч саад бэрхшээлгүйгээр зайлшгүй шаардлагатай эмнэлгийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэхийг дэмжинэ.

Нэгдсэн аналитик дүгнэлт

МАН болон ИЗНН "нийтийн эрүүл мэндийн баталгааг хадгалах" гэсэн нийтлэг байр суурьтай бол АН гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хоёуланд ижлээр хэрэглэх замаар чанарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх байр суурьтай. Үндэсний Эвсэл хамгийн чөлөөт зах зээлийн хандлагатай. Намуудын байр суурь нийтийн эрүүл мэнд нь "нийтийн үйлчилгээ" (public good) мөн эсэх, төрийн үүргийн хил хязгаар хаана байх вэ гэсэн суурь асуудалд үзэл баримтлалын зааг ялгааг тусгаж байна. Katz & Mair (1995)-ийн онолын дагуу энэ ялгаа нь намуудын үзэл баримтлалын жинхэнэ агуулгыг тодруулж байна²² гэж үзлээ.

3.2 Боловсролын Салбар

3.2.1 Төрийн болон хувийн боловсролын байгууллагын харьцаа

МАН - Монгол Ардын Намын байр суурь

Төрийн болон хувийн боловсролын байгууллагын харилцааг өрсөлдөөн бус, нэг зорилготой, чанар ба тэгш боломжид суурилсан хамтын оролцооны тогтолцоо гэж үздэг. Боловсрол нь төрийн үндсэн үүрэг бүхий нийтийн үйлчилгээ бөгөөд санхүүжилт нь өмчийн хэлбэрийг дагасан давуу байдал бус, хүүхэд бүрт чанартай үйлчилгээ хүргэх зорилготой байх ёстой. Хувийн хэвшлийг нэмэлт хүчин чадал, сонголтын боломж, инновацын оролцогч гэж үзнэ.

АН - Ардчилсан Намын байр суурь

Сургалтын чанарыг өмчийн хэлбэрийн өөрчлөлтөөс илүүтэй системийн шинэчлэлээр дэмжих байр суурьтай. Нэгдсэн цахим сургалтын сан, контент, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлснээр төрийн болон хувийн сургуулиудын хооронд үүсдэг чанарын ялгааг бууруулах бодлого баримтална. Боловсролын

²² Katz, R. S., & Mair, P. (1995). Changing Models of Party Organization and Party Democracy. Party Politics, 1(1), 5–28.

чанар нь сургуулийн өмчийн хэлбэрээс бус, сургалтын агуулга, суралцагчийн ахиц дэвшлээс хамаарах тогтолцоонд шилжинэ.

Үндэсний Эвслийн байр суурь

Төрийн болон хувийн хэвшлийн аль ч хэлбэрт боловсролын чанарыг онцгойлон анхаарч тооноос илүү чанарт шилжих бодлогыг дэмжиж ажиллана. СӨБ болон ЕБ-д сургалтын орчныг сайжруулах, эрүүл тогтвортой, ногоон сургууль цэцэрлэгийг олноор байгуулахыг дэмжинэ. Дээд боловсролын шатанд их дээд сургуулийн тоог цөөлж, чанарыг сайжруулж, хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах бодлогыг дэмжинэ.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, 1 насны хүүхдийг хамруулах боломжийг бүрдүүлнэ. Хүртээмжтэй тэгш хамран сурах боломжийг бүрдүүлэх, боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, боловсролын сангийн хөрөнгийг бүх шатанд ил тод, тэгш хуваарилах тогтолцоог бүрдүүлнэ. Орчин үеийн технологи, сурган хүмүүжүүлэх арга барил, боловсролын загваруудыг хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллагуудтай түншлэх замаар инновацыг дэмжинэ.

Нэгдсэн аналитик дүгнэлт

Дөрвөн нам бүгд боловсролыг нийтийн үйлчилгээ гэж үзэж, төрийн зохицуулалт хадгалагдах байр суурьтай нийцэж байна. Гол ялгаа нь хуваарилалтын механизмд байна: МАН болон АН өмчийн хэлбэрээс үл хамаарсан чанарын тэгш стандарт нэвтрүүлэхийг; Үндэсний Эвсэл тооны бус чанарын тэнцвэрийг (их сургуулийн тоо цөөлөх); ИЗНН хамрагдалтын өргөжилт, санхүүжилтийн ил тод байдлыг онцолж байна. Олон улсын жишгээр ерөнхий боловсролын салбарт төрийн оролцоо 80–90%-ийг эзэлдэг бөгөөд энэ нь дөрвөн намын байр суурьтай нийцэж байна.

3.2.2 Хот, хөдөөгийн боловсролын чанар, хүртээмжийн ялгааг бууруулах

МАН - Монгол Ардын Намын байр суурь

"Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "гэрт ойр сургууль, цэцэрлэг" гэсэн бодлогыг хэрэгжүүлнэ. Малчин өрх, алслагдсан сум, баг, нийгмийн эмзэг бүлгийн хүүхдийн боловсролын тэгш хүртээмжийг тусгайлан анхаарна. Цахим боловсролыг хот, хөдөөгийн ялгааг бууруулах стратегийн хэрэгсэл болгоно. Тусгай хэрэгцээт хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохируулгат орчин нэмэгдүүлэх нь боловсролын тэгш хүртээмжийн салшгүй хэсэг юм.

АН - Ардчилсан Намын байр суурь

PISA үнэлгээний дүнгийн дагуу аймгийн төвийн сургуулиуд нийслэлийнхээс дунджаар 1-1.5 жил, харин сумын төвийнх аймгийн төвийнхөөс 1.5-2 жил хоцрогдож байгааг бодлогын суурь болгон авч үздэг. Алслагдсан орон нутгийн сургуулиудыг нэгдсэн цахим сургалтын платформд бүрэн холбох; орон нутгийн болон нийслэлийн зөрүүг технологийн шийдлээр нөхөх байр суурийг баримтална.

Үндэсний Эвслийн байр суурь

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутагт ажлын байрыг олноор бий болгох, улмаар төвлөрлийг сааруулан, орон нутагт боловсролын чанар сайжрах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны илчлэг чанар, хүртээмжийг дээшлүүлнэ. Сургуулийн орчинд хүүхдийн аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтээс ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Дижитал бичиг үсгийн ур чадвар, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд анхаарч, сургалтын хөтөлбөр боловсруулах, боловсролын нөөцөд хөрөнгө оруулалт хийх замаар сургалтын чанарыг сайжруулна.

Нэгдсэн аналитик дүгнэлт

МАН болон АН хоёул цахим сургалтыг стратегийн хэрэгсэл болгосон нь нийтлэг нийцтэй. МАН "нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги" гэх тодорхой, хэрэгжихүйц зорилт тавьсан нь илүү нарийн загвар юм. АН PISA өгөгдөлд тулгуурлан нотолгоонд суурилсан байр суурийг баримталсан нь бодлогын шинжлэх ухааны хандлагыг илэрхийлж байна.²³ Үндэсний Эвсэл бүтцийн шийдлийг (ажлын байр, суурьшил) онцолсон нь өргөн хүрээний бодлогын зорилгоор боловсролын асуудлыг шийдвэрлэх хандлага юм. ИЗНН хүүхдийн хамгааллын хэмжээс, хоол тэжээл, орчны аюулгүй байдлыг сургалтын чанарын салшгүй хэсэг гэж үзсэн нь ногоон үзэл баримтлалтай нийцэж байна.

3.2.3 Боловсролын салбарын багш, ажилчдын хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмж

МАН - Монгол Ардын Намын байр суурь

²³ Dalton, R. J., & Wattenberg, M. P. (Eds.). (2000). Parties without Partisans. Oxford University Press.

"Сайн багшийг таны дэргэд" цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. Багш, ажилчдын цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгааг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттай сайжруулна. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн тогтолцоог бэхжүүлж, ажлын ачааллыг бууруулна. Гүйцэтгэлийн үнэлгээг сурагчийн ахиц, ангийн орчин, мэргэжлийн хөгжил, хамтын ажиллагааны үр дүнтэй уялдуулна.

АН - Ардчилсан Намын байр суурь

Багшийн ажлын гүйцэтгэлийг суралцагчийн ахиц, бодит үр дүнтэй уялдуулан үнэлэхэд чиглэнэ. Тайлан, бичиг цаасны ажлыг технологийн шийдлээр автоматжуулах, багшийн үндсэн үүрэг болох хүүхэдтэй ажиллах цагийг нэмэгдүүлэх, уян хатан ажлын цагийн зохицуулалт, дата, технологид суурилсан хяналт, үнэлгээний систем нэвтрүүлэх арга хэмжээ авна.

Үндэсний Эвслийн байр суурь

Боловсролын салбарын урсгал зардлыг бууруулах замаар багш ажилчдын цалинг нэмэх боломжтой гэж үздэг. Тухайлбал, ногоон сургууль барьснаар сургуулийн халаалтын зардал эрс буурч, хэмнэсэн зардлаар багшийн цалинг нэмэх боломжтой. Дотоод агаарын чанар сайтай сургуулиуд олширсноор хүүхдийн өвчлөл буурч, багшийн ажлын орчин нөхцөл сайжирна.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Багш бэлтгэх, ажлын байрны стандартыг сайжруулах, нийгмийн хангамжийг нэмэгдүүлж, төрийн тусгай албан хаагчийн ангилал зэрэглэлд хамруулж урамшууллын цогц бодлогыг хэрэгжүүлнэ. Багшлах боловсон хүчний мэргэжлийг гадаад, дотоодын өндөр түвшний сургуулиудад дээшлүүлэх, үнэт тэтгэлэгт хамрагдах давуу боломжийг бүрдүүлнэ.

Нэгдсэн аналитик дүгнэлт

Дөрвөн нам бүгд багшийн цалин, үнэлэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа нь нийтлэг байр суурь юм. Гол ялгаа нь хэрхэн хэрэгжүүлэх аргачлалд байна: **МАН** цогц тогтолцооны шинэчлэл, **АН** гүйцэтгэлд суурилсан үнэлгээ болон технологийн автоматжуулалт; **Үндэсний Эвсэл** урсгал зардал хэмнэлтийн шинэлэг шийдэл; **ИЗНН** хуулийн статус дээшлүүлэх, тэтгэлгийн боломж нэмэгдүүлэх аргыг тус тус санал болгосон.

3.3 Жижиг, Дунд Бизнесийн Бодлого

3.3.1 ЖДҮ-ийг дэмжих хүрээнд татварын орчин

МАН - Монгол Ардын Намын байр суурь

ЖДҮ-ийн татварын бодлого нь бизнесийг шахах бус, албан эдийн засагт оруулах, өсгөх, ажлын байр нэмэгдүүлэх, хариуцлагатай татвар төлөгчийг урамшуулах зарчимд суурилна. Бизнесийн эхний үе шатанд татварын дарамтыг бууруулах, тайлагналыг хялбаршуулах, цахим татварын тогтолцоог боловсронгуй болгоно. Орон нутаг, бүсийн онцлогт нийцсэн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг татварын бодлогоор дэмжинэ. Тогтвортой ажлын байр бий болгосон бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжинэ.

АН - Ардчилсан Намын байр суурь

Тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой, өрсөлдөөнд ээлтэй татварын орчин бүрдүүлэх байр суурьтай. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд нэг шатлалт хялбар татварын тогтолцоо (орлогоос 1–3%) нэвтрүүлж, тайлагналын зардал болон албан бус байдлыг бууруулна. Нийлүүлэлтийн сүлжээнд холбогдсон ЖДҮ-д татварын урамшуулал (буцаан олголт, хөнгөлөлт) олгож, кластер хөгжлийг дэмжинэ. Татварын орчны тогтвортой байдлыг хангаж, хуулийг буцаан үйлчлүүлэхгүй байх зарчмыг баталгаажуулна.

Үндэсний Эвслийн байр суурь

ЖДҮ-ийн татварыг эрс бууруулах шаардлагатай гэж үздэг. Гарааны бизнес болон инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлттэй хугацаа олгох, хэрэв экспортолдог бол эдийн засгийн чөлөөт бүсүүдэд дунд болон урт хугацаандаа давуу эрхээр ажиллах боломж бүрдүүлэх бодлого баримтална.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Прогрессив татварын тогтолцоог нэвтрүүлэх, орлогын тэгш бус байдлыг бууруулах, жижиг дунд бизнесийг дэмжих, иргэд болон бүх бизнес эрхлэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэн ажиллана. Нийгмийн даатгалын бодлогын цогц шинэчлэл хийнэ.

Нэгдсэн аналитик дүгнэлт

МАН болон АН хоёул "бизнесийг шахах бус, өсгөх" зарчмыг баримталсан нийтлэг байр суурьтай. МАН орон нутгийн ЖДҮ болон ажлын байр бий болгосон бизнест тусгай анхаарал хандуулсан нь нийгмийн ардчиллын үзэл баримтлалтай нийцэж байна. АН "буцаан үйлчлэхгүй байх зарчим" гэж хуулийн тогтвортой байдлыг онцолсон нь эрх зүйн баталгаажуулалтын хандлагыг илэрхийлж байна. Үндэсний Эвсэл татварыг "эрс бууруулах" гэсэн хамгийн радикал байр суурьтай бол ИЗНН прогрессив татварын тогтолцоогоор тэгш байдлыг хангахыг голлосон. Энэ хоёр байр суурь үзэл баримтлалын гүн ялгааг харуулж байна.

3.3.2 ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмж

МАН - Монгол Ардын Намын байр суурь

Санхүүжилтийн бодлого нь цөөн тооны төсөлд төвлөрсөн, барьцаа хөрөнгөнд хэт тулгуурласан хэлбэрээс гарч, ил тод сонгон шалгаруулалт, зээлийн батлан даалт, урт хугацаатай, хүү багатай зээл, лизинг, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт, ногоон зээл, экспортын өмнөх санхүүжилт зэрэг олон төрлийн хэрэгслийг хөгжүүлнэ. Төрийн худалдан авалтаар дамжуулан ЖДҮ-ийн борлуулалтыг дэмжих практик механизм нэмэлт шийдэл болно. Санхүүжилтийг ил тод, цахим, шалгуурт суурилсан болгоно.

АН - Ардчилсан Намын байр суурь

ЖДҮ-ийн санхүүжилтийг төрөөс шууд олгох бус, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтална. Зээлийн батлан даалтын тогтолцоог өргөжүүлж, банк, ЖДҮ-ийн эрсдэлийг хуваалцах (30–50%) механизм нэвтрүүлнэ. Барьцааны эрх зүйн орчныг шинэчилж, мал, тоног төхөөрөмж, гэрээ, нэхэмжлэл зэргийг барьцаанд ашиглах боломж нэмэгдүүлнэ. Венчур болон “анжел” хөрөнгө оруулалтын зардлыг ААНОАТ-аас хөнгөлөх схем бий болгоно.

Үндэсний Эвслийн байр суурь

ЖДҮ-ийн хөгжүүлэх сангийн хэмжээг нэмэгдүүлж, хүрэх ёстой эздэд нь хүргэж өгөх нь чухал байна. Нэг аж ахуйн нэгжид олгох хэмжээг хэт их биш, харин аль болох олон аж ахуйн нэгжид хүртээх бодлого баримтална.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр бий болгоход чиглэсэн зээл, урамшуулалд тавих хяналтын тогтолцоо бүрдүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, эмзэг бүлгийн иргэдийн орлого, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх чиглэлд ажиллана.

Нэгдсэн аналитик дүгнэлт

МАН болон АН хоёул барьцаа хөрөнгийн хязгаарлалтаас гарах шийдлийг санал болгосон нь нийтлэг асуудлын нийтлэг оношилгоог харуулж байна. МАН "төрийн худалдан авалтаар борлуулалт дэмжих" практик механизмыг тусгайлан онцолсон нь АН-ын зах зээлд суурилсан хандлагаас ялгарч байна. Үндэсний Эвсэл "өргөн хүртээмжтэй" гэдгийг тэргүүлсэн нь тэгш байдлын хэмжүүрийг онцолсон байр суурь. ИЗНН хяналтын тогтолцоог бэхжүүлэхийг голлосон нь санхүүжилтийн ашиглалтын үр ашиг, ил тод байдлыг онцолж байгааг харуулж байна.

3.3.3 Гарааны бизнес, инновацыг дэмжих бодлого

МАН - Монгол Ардын Намын байр суурь

Гарааны бизнес, инновацыг Монгол Улсын эдийн засгийг уул уурхайгаас хэт хамааралтай бүтцээс гаргах шинэ өсөлтийн чиглэл гэж үздэг. Залуучуудыг зөвхөн ажил хайгч бус, шинэ бизнес, шинэ ажлын байр бий болгогч болгох бодлого баримтална. Их сургууль, судалгаа, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны экосистем хөгжүүлж, matching fund механизм, технологи дамжуулах төв, инкубатор, акселератор, оюуны өмчийн хамгаалалтыг дэмжинэ.

АН - Ардчилсан Намын байр суурь

Бизнесийн бүртгэл, зөвшөөрлийн үйл явцыг бүрэн цахимжуулж, "нэг цонхны" системээр 24 цагийн дотор бүртгэх боломж бүрдүүлнэ. Fintech, агро-технологии, ногоон технологийн салбарт "regulatory sandbox" орчин бүрдүүлж, инновацыг бодит нөхцөлд турших боломж олгоно. Монгол Улсын онцлог давуу тал болох хүйтэн уур амьсгал, сэргээгдэх эрчим хүчний нөөцөд тулгуурлан ногоон дата төв зэрэг дижитал экспортын стартапуудыг дэмжинэ.

Үндэсний Эвслийн байр суурь

Гарааны бизнес болон инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлттэй хугацаа олгох, хэрэв экспортолдог бол эдийн засгийн чөлөөт бүсүүдэд дунд болон урт хугацаандаа давуу эрхээр ажиллах боломж бүрдүүлэх бодлого баримтална.

ИЗНН - Иргэний Зориг Ногоон Намын байр суурь

Тогтвортой ногоон технологийг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний системийг дэмжих замаар ногоон эдийн засгийн аливаа шийдлийг тууштай дэмжинэ. Орчин үеийн технологи, сурган хүмүүжүүлэх арга барил, боловсролын загваруудыг хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллагуудтай түншлэх замаар инновацыг дэмжинэ.

Нэгдсэн аналитик дүгнэлт

МАН болон АН хоёул "ecosystem" хандлагыг баримталсан нь дэлхийн инновацын нийгэмлэгийн судалгаатай нийцэж байна.²⁴ МАН "matching fund" механизмыг тусгайлан дурдсан нь АН-ын "regulatory sandbox" тай хамт бодлогын нарийн хэрэгслийг тодорхойлж чадсаныг харуулж байна. Үндэсний

²⁴ Autio, E., & Levie, J. (2017). Management of Entrepreneurial Ecosystems. In The Wiley Handbook of Entrepreneurship. Wiley.

Эвсэл чөлөөт бүсэд суурилсан давуу эрхийн загварыг санал болгосон нь харьцангуй тодорхой, тун хэрэгжихүйц байр суурь юм. ИЗНН тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан инновацыг ногоон эдийн засгийн чиглэлд хөгжүүлэхийг дэмжсэн нь ялгагдах онцлог байр суурь юм.

4. Дүгнэлт

Дөрвөн намын байр суурийг харьцуулахад нийтлэг нийцтэй чиглэлүүд байгаа нь Монгол Улсын тулгамдсан асуудлуудыг намын үзэл баримтлалаас үл хамааран хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна. Тухайлбал, анхан шатны эрүүл мэнд үйлчилгээг сайжруулах, хот хөдөөгийн ялгааг бууруулах, ЖДҮ-д тааламжтай орчин бүрдүүлэх нь дөрвөн намын нийтлэг байр суурь юм.

МАН болон АН хоёрын байр суурь нийгмийн ардчилал ба баруун төвийн либерализмын ялгааг тодорхой илэрхийлж байна. МАН тэгш хүртээмж, төрийн зохицуулалт, хувийн хэвшилтэй түншлэлийн тэнцвэрийг, АН зах зээлийн механизм, хувийн хэвшлийн өрсөлдөөн, эрх зүйн шинэчлэлийг голлож байна.

Ашигласан ном, эх сурвалж

- Huntington, S. P. (1968). *Political Order in Changing Societies*. Yale University Press.
- Mainwaring, S. (1999). *Rethinking Party Systems in the Third Wave of Democratization*. Stanford University Press.
- Нээлттэй Нийгэм Форум. (2021). Чухал сэдэв: Бодлогын хэлэлцүүлэг. Цуврал No1.
- Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга. (2023). Төрийн мэдээлэл эмхэтгэл, No30. <https://legalinfo.mn>
- Монгол Ардын Намын албан ёсны цахим хуудас. <https://www.nam.mn/program>
- Ардчилсан Намын албан ёсны цахим хуудас. <http://www.democraticparty.mn/page/85>
- ХҮН Намын албан ёсны цахим хуудас. <https://www.hunnam.mn/manifesto>
- Төрийн Аудитын Байгууллага. (2024). "Үндэсний эвсэл"-ийн аудитын дүгнэлт, No1059.
- Төрийн Аудитын Байгууллага. (2024). "Иргэний зориг ногоон нам"-ын аудитын дүгнэлт, No1060.
- Burke, E. (1770). *Thoughts on the Cause of the Present Discontents*. London: Dodsley.
- Dalton, R. J., & Wattenberg, M. P. (Eds.). (2000). *Parties without Partisans*. Oxford University Press.
- Manin, B. (1997). *The Principles of Representative Government*. Cambridge University Press.
- Przeworski, A., Stokes, S. C., & Manin, B. (Eds.). (1999). *Democracy, Accountability, and Representation*. Cambridge University Press.
- Katz, R. S., & Mair, P. (1995). Changing Models of Party Organization and Party Democracy. *Party Politics*, 1(1), 5–28.
- Strom, K. (1990). A Behavioral Theory of Competitive Political Parties. *American Journal of Political Science*, 34(2), 565–598.
- Habermas, J. (1996). *Between Facts and Norms*. MIT Press.
- Mudde, C., & Kaltwasser, C. R. (2017). *Populism: A Very Short Introduction*. Oxford University Press.
- OECD. (2016). *Financing Democracy: Funding of Political Parties and Election Campaigns*. OECD Publishing.
- Авлигатай Тэмцэх Газар (АТГ). (2023). Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан. Улаанбаатар.
- Mainwaring, S., & Torcal, M. (2006). Party System Institutionalization and Party System Theory. In *Handbook of Party Politics*. SAGE Publications.
- Norris, P. (2011). *Democratic Deficit: Critical Citizens Revisited*. Cambridge University Press.
- Katz, R. S., & Mair, P. (2009). The Cartel Party Thesis: A Restatement. *Perspectives on Politics*, 7(4), 753–766.

- Mainwaring, S., & Scully, T. R. (Eds.). (1995). Building Democratic Institutions. Stanford University Press.
- Weber, M. (1946). From Max Weber: Essays in Sociology. Oxford University Press.
- Kirchheimer, O. (1966). The Transformation of the Western European Party Systems. In Political Parties and Political Development. Princeton University Press.
- Transparency International. (2020). Political Finance Regulations Around the World. TI Report.
- Dalton, R. J. (2004). Democratic Challenges, Democratic Choices. Oxford University Press.
- Michels, R. (1911/1962). Political Parties. Free Press.
- Porter, M. E., & Teisberg, E. O. (2006). Redefining Health Care: Creating Value-Based Competition on Results. Harvard Business Press.
- Autio, E., & Levie, J. (2017). Management of Entrepreneurial Ecosystems. In The Wiley Handbook of Entrepreneurship. Wiley.
- МАН. (2026). Монгол Ардын Намын бодлогын байр суурийн дэлгэрэнгүй хариу (Хавсралт бичиг).